Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн хэрэглээнд хийсэн судалгаа

Г.Бадамханд[1], Л.Цэрэнлхам[1], С.Пүрэвсүрэн[1]

[1]АШУҮИС-ийн Эм зүйн сургууль
Цахим шуудан: gankhulug.badamkhand@gmail.com, Утас: 99016069

Түлхүүр үг:

Артерийн гипертензи
Зүрх судасны өвчин
Эмийн үнийн хөнгөлөлт
Эмийн хэрэглээ

Товч утга:

Үндэслэл: Манай улсын хүн амын дунд артерийн гипертензи (АГ)-ийн тархалт өндөр байгаа ба Эрүүл мэндийн даатгалын сан (ЭМДС)-аас цусны даралт бууруулах эмэнд үнийн хөнгөлөлт үзүүлж байна. **Зорилго:** ЭМДС-аас 2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийг хэрэглээг судлах. **Арга, аргачлал:** ЭМДС-аас 2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн хэрэглээг нэг агшны аргаар ретроспектив загварыг ашиглан судаллаа. **Үр дүн:** ЭМДС-аас 2021 онд нийт 357755 эмчлүүлэгчдийн цусны даралт бууруулах эмэнд үнийн хөнгөлөлт үзүүлснээс 4-р улиралд 386391 (21.9%) эмийн жоронд үнийн хөнгөлөлт үзүүлсэн нь бусад улирлаас хамгийн бага үзүүлэлттэй байна. Насны бүлгээр авч үзвэл 55-59 насны 56947 (15.9%), 60-64 насны 57427 (16.1%), 65-аас дээш насны 106048 (29.6%) эмчлүүлэгч байгаа нь цусны даралт бууруулах эмийг хөнгөлөлттэй авсан нийт эмчлүүлэгчийн дийлэнх хувийг эзэлж байна. **Дүгнэлт:** ЭМДС-аас 2021 онд эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн хэрэглээ 65-аас дээш насны эрэгтэй хүмүүст их байгаа ба байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хот болон хангайн бүсийн эмчлүүлэгчдэд харьцангуй их тодорхойлогдсон нь хүн амын нягтаршил, газар зүйн онцлог, өвчлөлийн түвшин зэрэгтэй холбоотой байж болох юм. ЭМДС-аас 2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмэнд ангиотензины рецепторыг хориглогч эм, ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч эм дийлэнх хувийг эзэлж байгаа ба лозартан, лизиноприл, амлодипин, триметазидин эмийн хэрэглээ өндөр байна.

Үндэслэл: Зүрх судасны өвчнөөр жилд 17 сая орчим хүн нас барж байгаа нь дэлхийн нийт нас баралтын 1/3 орчим хувийг эзлэх ба үүнээс 9.4 сая тохиолдол нь артерийн гипертензи (АГ)-ийн хүндрэлтэй холбоотой (2019).[1] Дэлхий дахинд ойролцоогоор 1.4 тэрбум хүн АГ-тэй байгаагаас 14% нь АГ-ийг тогтмол хянаж чаддаг байна.[2] АГ-д эрэгтэй хүн илүү өртөх ба 2015 онд хийсэн судалгааны үр дүнгээс харахад таван эрэгтэй тутмын нэг, дөрвөн эмэгтэй тутмын нэг нь АГ-тэй бөгөөд 2025 онд АГ-ийн тархалт 30%-иар нэмэгдэнэ гэсэн тооцоолол бий.[2,3] Гучаас дээш насанд зүрх судасны өвчнөөр өвчлөх эрсдлийн түвшин АГ≥140/90 мм.муб-тай хүмүүст 63.3%, харин цусны хэвийн даралттай хүмүүст 46.1% байна.[4]

Монгол улсад хийгдсэн “Халдварт бус өвчин (ХБӨ) эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшинг тогтоох үндэсний IV судалгаа, STEPS 2019” судалгааны үр дүнгээс харахад Монгол улсад 15-69 насны АГ-тэй хүн амын эзлэх хувь 44.0% (95%ИХ 42.2-45.7), судалгааны явцад шинээр илэрсэн АГ-тэй хүн амын тархалт 55.5% (95%ИХ 52.7-58.4) байгаа нь АГ-ийн тархалт их байгааг харуулж байна.[5]

Монгол улсад “Насанд хүрэгсдийн артерийн гипертензийн эмнэлзүйн заавар”, “Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020 оны 13-р тогтоол”, “Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын хүрээнд ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлж байна. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020 оны 13-р тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар,

хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтад цусны даралт бууруулах ерөнхий нэршлийн 27, худалдааны нэршил бүхий 63 эм багтсан ба эдгээр эмэнд 30-70%-ийн үнийн хөнгөлөлт үзүүлдэг юм.

Үнийн хөнгөлөлт үзүүлсэн эмийн хэрэглээний судалгаа хийх нь энэ талаарх мэдээллийг бүрдүүлж, цаашид үнийн хөнгөлөлт үзүүлэх үйл ажиллагаанд суурь мэдээлэл болох юм.

Зорилго: ЭМДС-аас 2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийг хэрэглээг судлах

Зорилт:

1. ЭМДС-аас 2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн тархалтыг насны бүлэг, хүйс, газар зүйн байрлаар тогтоох
2. ЭМДС-аас 2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн нэр төрөл, олгосон эмийн тоо хэмжээг судлах

Арга, аргачлал: Уг судалгааг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар ёс зүйн зөвшөөрөл авч хийсэн. ЭМДС-аас 2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн тайлан мэдээг ашиглан нэг агшны судалгааны аргаар ретроспектив загварыг ашиглан судалгааг явуулав. ЭМДС-ийн цахим мэдээний сангийн цусны даралт бууруулах эмийн мэдээллээс судалгааны карт (эмчлүүлэгчийн нас, хүйс, онош, газар зүйн байршил)-ыг ашиглан мэдээллийг түүвэрлэсэн. Статистик боловсруулалтыг STATA 17, Jamovi программыг ашиглан хийж гүйцэтгэв.


Үр дүн: ЭМДС-аас 2021 онд 1756773 жоронд бичигдсэн цусны даралт бууруулах эмэнд үнийн хөнгөлөлт үзүүлсэн ба үүнд нийт 357755 эмчлүүлэгч хамрагджээ. Эмчлүүлэгч бүрд жилд 4-5 удаагийн давтамжтайгаар эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Эмчлүүлэгчдийн ерөнхий мэдээллийг хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагсадын ерөнхий мэдээлэл (N=357755)

Үзүүлэлт		%	Нийт тоо
Хүйс	Эрэгтэй	65.6	234528
	Эмэгтэй	34.4	123227
Насны бүлэг	55-59 нас	15.9	56947
	60-64 нас	16.1	57427
	65-аас дээш	29.6	106048
Харьяалал	Хот	49.4	176730
	Хөдөө	50.6	181025


2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах нийт эмэнд ангиотензины рецепторыг хориглогч эм 16%, ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч 12%-ийг тус тус эзэлж байна. Нийт үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмэнд экватор 5мг/10мг, 20мг/10мг шахмал 13%, лозартан 50мг/100мг шахмал 8.7%, амлодипин 10 мг (амло-денк) шахмал 7.7%, лизиноприл 10мг/20мг шахмал 7.2%, триметазидин 35 мг шахмал 3.3%-ийг тус тус эзэлж байв.

АГ оношийн дагуу 1756773 жоронд бичигдсэн цусны даралт бууруулах эмэнд үнийн хөнгөлөлт үзүүлснээс IV улиралд 386391 (21.9%) жороор эм олгосон нь бусад улирлаас хамгийн бага, 12 дугаар сард 76653 (4.4%) жороор эм олгосон нь бусад сараас хамгийн бага үзүүлэлттэй байна (Зураг 1).




Зураг 1. ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн жорын тоо (Сараар)

ЭМДС-аас АГ оношийн дагуу хөнгөлөлттэй олгосон цусны даралт бууруулах эмийг Улаанбаатар хотод 867671 (49.3%), Баян-Өлгий аймагт 70544 (4%), Орхон аймагт 67640 (3.8%), Хөвсгөл аймагт 61802 (3.5%) жороор олгосон нь тархалтын ихэнх хувийг эзлэж байна (Зураг 2).



Зураг 2. ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн жорын тоо (аймгаар), 2021 он

Үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн 45% (n=162048)-ийг Улаанбаатар хотод олгосон ба орон нутгийг газар зүйн бүсээр авч үзвэл Хангайн бүсэд 70966 (20%), Төвийн бүсэд 54135 (15%), Баруун бүсэд 47534 (13%), Зүүн бүсэд 23072 (7%) эмчлүүлэгчид үнийн хөнгөлөлт үзүүлсэн байна (Зураг 3).



Зураг 3. ЭМДС-аас АГ оношоор эмийн үнийн хөнгөлөлт авсан эмчлүүлэгчид (бүсээр), 2021 он

Хэлцэмж: Цусны даралт бууруулах эмийн үнийн хөнгөлөлт авсан эмчлүүлэгчдийг хүйсээр авч үзвэл 65.6% (234528) нь эрэгтэй, 34.4% (123227) нь эмэгтэй байв. "Эрүүл мэндийн үзүүлэлт 2021" эмхэтгэлээс харахад АГ өвчин зүрх судасны тогтолцооны өвчний дотор 2021 оны байдлаар 51.6% хувийг эзэлж, 10000 хүн амд 483 байгаа ба нийт өвчлөгсдийн 53.9% нь эмэгтэй, 47.6% нь эрэгтэй байв[6]. Хэдийгээр АГ-ийн нийт тохиолдлын дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан ч ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт авсан эмчлүүлэгчдэд эрэгтэй эмчлүүлэгч ихэнх хувийг эзэлж байна. Энэ нь зарим эмчлүүлэгч 1-2 удаа, зарим эмчлүүлэгч 4-5 удаа эмийн үнийн хөнгөлөлт авсантай холбоотой байж болох юм.

Цусны даралт бууруулах эмийн үнийн хөнгөлөлт авсан эмчлүүлэгчдийг газар зүйн байршлаар авч үзвэл Хангайн бүс 20% (n=70966), Төвийн бүс 15% (n=54135), Баруун бүс 13% (n=47534), Зүүн бүс 7% (n=23072) харин Улаанбаатар хот 45% (n=162048) байв. "Халдварт бус өвчин (ХБӨ)-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшинг тогтоох үндэсний IV судалгаа, STEPS 2019" судалгаанд АГ-ийн тархалт Баруун бүс (44.6%), Төвийн бүс (42.3%)-д өндөр байсан[5] нь бидний судалгааны ажлын үр дүнтэй дүйж байна.

Дүгнэлт:

1. ЭМДС-аас 2021 онд эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмийн хэрэглээ 65-аас дээш насны эрэгтэй хүмүүст их байгаа ба байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хот болон хангайн бүсийн эмчлүүлэгчдэд харьцангуй их тодорхойлогдсон нь хүн амын нягтаршил, газар зүйн онцлог, өвчлөлийн түвшин зэрэгтэй холбоотой байж болох юм.
2. ЭМДС-аас 2021 онд үнийн хөнгөлөлт үзүүлсэн цусны даралт бууруулах эмэнд ангиотензины рецепторыг хориглогч эм, ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч эм дийлэнх хувийг эзэлж байгаа ба лозартан, лизиноприл, амлодипин, триметазидин эмийн хэрэглээ өндөр байна.

Ном зүй:

1. *Ana Paula Rodrigues, Vânia Gaio. Sociodemographic disparities in hypertension prevalence: Results from the first Portuguese National Health Examination Survey. Rev Port Cardiol (Engl Ed). 2019 Aug;38(8):547-555.*
2. *WHO.Guideline for the pharmacological treatment of hypertension in adults; 2022.01*
3. *Azmawati Mohammed Nawi, Zulkefley Mohammad. The Prevalence and Risk Factors of Hypertension among the Urban Population in Southeast Asian Countries: A Systematic Review and Meta-Analysis. 2021 Feb 10;2021:6657003.*
4. *Eleni Rapsomaniki, Adam Timmis . Blood pressure and incidence of twelve cardiovascular diseases: lifetime risks, healthy life-years lost, and age-specifi c associations in 1·25 million people. 2014 May 31;383(9932):1899-911.*
5. *Халдварт бус өвчин,осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын үндэсний IV судалгаа, STEPS-2019.х.116-124*
6. *Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт 2021.х.120-121. Retrieved October 10, 2022. Available at: http://hdc.gov.mn/media/uploads/2022-09/2021.pdf*
7. *Эрүүл мэндийн даатгалын газар. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны статистик эмхэтгэл; 47-55*
8. *Эрүүл мэндийн даатгалын газар. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны эхний хагас жилийн статистик эмхэтгэл; 105-120*

A study on the use of antihypertensive drugs discounted from the Health Insurance Fund in 2021

Badamkhand G[1], Tserenlkham L[1], Purevsuren S[1]

[1]School of Pharmacy, MNUMS
E-mail: gankhulug.badamkhand@gmail.com, Tel: +976-99016069

Background: The prevalence of arterial hypertension is high among the population of our country, and the Health Insurance Fund (HIF) provides price discounts for antihypertensive drugs.
Aim: To study the use of antihypertensive drugs discounted from the HIF in 2021.
Materials and Methods: The use of antihypertensive drugs discounted from the HIF in 2021 was studied by cross sectional method using a retrospective design.
Results: In 2021, 357755 patients received price discounts on antihypertensive drugs from the HIF, and in the fourth quarter, 386391 (21.9%) patients received price discounts, which was the least compared to other seasons. By age group, 56947 (15.9%) patients aged 55-59, 57427 (16.1%) patients aged 60-64, and 106048 (29.6%) patients over 65 years of age received discounted antihypertensive drugs.
Conclusion: In 2021, the use of antihypertensive drugs discounted from the HIF was high among men over 65 years of age and it was relatively high among Ulaanbaatar city and Khangai region, which may be related to population density, geographic characteristics, and the level of disease. Angiotensin receptor blockers and angiotensin-converting enzyme inhibitors were the majority of antihypertensive drugs discounted from the HIF, and the use of losartan, lisinopril, amlodipine, and trimetazidine was high in 2021.

Keywords: Arterial hypertension, cardiovascular disease, drug discount, drug use